ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 17 өдөр Дугаар 88 Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн 2016, 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 257.0 (хоёр зуун тавин долоон) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1."Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн 2016, 2017 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2."Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Х.Алтайд дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

2.2.Компанийн хөрөнгийг зохистой удирдах, авлага, өглөгийг бууруулах, харилцагчтай үлдэгдэл төлбөр тооцоог нийлж баталгаажуулах, нэг жилээс дээш хугацаатай авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх;

2.3.Дутагдсан үндсэн хөрөнгийг гэм буруутай этгээдээр нь төлүүлэх талаар мэдэгдэж, хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

2.4.Нягтлан бодох бүртгэлд бүртгэлгүй "Анард" ХХК-ийн барьсан барилга байгууламжийг бүртгэлд тусгах арга хэмжээ авах;

2.5.Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны 2012 оны 353 дугаар тогтоолын дагуу "Анард" ХХК-иас авах 67,130,000 төгрөгийн авлагыг төлүүлэх талаар зохих арга хэмжээ авах;

2.6.Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд байршилтай биржийн туслах аж ахуй, үр тарианы зориулалттай эзэмших эрхийн гэрчилгээтэй газрын асуудлыг шийдвэрлэх;

2.7.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах болон энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах, биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.ЭРДЭНЭХИШИГ

000157 1

D:\Huraldaanii material\2018 on\2018.04.17\07docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 04 дугаар сарын 14-ний өдрийн
88 дугаар тогтоолын хавсралт

"Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн шалгалтаар илэрсэн
зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /төгрөгөөр/	Зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасныг зөрчиж найдваргүй болох эрсдэлтэй 1 жилээс дээш хугацаатай авлага үүсгэсэн	Гүйцэтгэх захирал, Захиргаа, санхүүгийн газар	219,833,887.78	Төсвийг зохистой удирдаж, авлагыг бууруулах арга хэмжээ авах, харилцагчтай үлдэгдэл төлбөр тооцоо нийлэх, нэг жилээс дээш хугацаатай авлагыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэх
2	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчиж байгууллагын үндсэн хөрөнгийг дутагдуулсан	Гүйцэтгэх захирал, Захиргаа, санхүүгийн газар	4,000,000.00	Холбогдох ажил хариуцаж байсан болон дутагдуулсан этгээдээр төлүүлэх талаар хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэх
3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8, 19, 48 дугаар зүйлд заасныг зөрчиж худалдан авалт хийсэн	Гүйцэтгэх захирал, Захиргаа, санхүүгийн газар	33,199,000.00	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, зохион байгуулалт, тайланг хуулийн дагуу хэрэгжүүлэх, төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийхгүй байх, нийт төсөвт өртгийг үндэслэх, жишиг баримт бичгийг ашиглах
Зөрчил, дутагдлын нийт дүн			**257,032,887.78**	